

БАТЛАВ
МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР
САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН САЙД

БАТЛАВ
МОНГОЛ УЛСЫН ШАДАР
САЙД

Ж.ЭНХБАЯР

Т.ДОРЖХАНД

БАТЛАВ
САНГИЙН САЙД

БАТЛАВ
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

З.МЭНДСАЙХАН

С.АМАРСАЙХАН

2026 оны 05 дугаар сарын ...-ны өдөр

БИЗНЕСИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод “...эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, дотоод хэрэгцээгээ өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай улс болно” гэж, “бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх” гэсэн зорилтыг дэвшүүлсэн.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн “Эдийн засгийн бодлого” гэсэн 3 дугаар бүлэгт “Зах зээл дэх төрийн оролцоог бууруулж, бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулан, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлж, олон тулгуурт, хүртээмжтэй, экспортын баримжаатай эдийн засгийг бэхжүүлнэ” гэж, тус бүлгийн 3.1-д заасан “Эдийн засгийн эрх чөлөө” хэсгийн 3.2.2.1-д “Хөрөнгө оруулалтын тухай хууль болон бизнесийн үйл ажиллагааг зохицуулж байгаа хуулиудыг шинэчилж, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, бизнес эрхлэгчийг дэмжих эрх зүйн орчныг боловсронгуй болгоно” гэж, 3.2.2.3-т “Шинэ аж ахуйн нэгжүүдийн зах зээлд нэвтрэхэд тулгардаг саад хоригийг арилгаж, гарааны компаниудын бизнесийг дэмжих экосистемийг бүрдүүлэх, зах зээлийн чөлөөт өрсөлдөөнийг дэмжих, монополын эсрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ” гэж, 3.2.2.4-т “Төрийн байгууллагуудаас зөвшөөрөл олгох үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, зөвшөөрлийн нэгдсэн платформыг эхлүүлнэ” гэж тус тус заасан.

Бизнес, худалдаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа нь эдийн засгийн бүх салбар, үйл ажиллагааг хамарсан өргөн хүрээний асуудал тул Монгол Улсын хөгжлийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг улс, бүс, салбар, салбар хооронд болон орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах, бизнес, хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэлээр төрийн байгууллагын уялдаа холбоог хангасан нэгдсэн зохицуулалт хийх шаардлагатай байна.

Монгол Улсад бизнес эрхлэхтэй холбоотой харилцааг шууд болон шууд бусаар зохицуулсан 360 гаруй хууль хүчин төгөлдөр үйлчилж байгаа ч бизнесийн үйл ажиллагааны явцад төр болон бизнес эрхлэгчдийн хооронд баримтлах зарчмууд тухайлбал, хуулиар хориглосноос бусад тохиолдолд бизнесийн үйл ажиллагааг чөлөөтэй эрхлэх, бизнесийн тогтвортой байдлыг хангах, төр, хувийн аж ахуй нэгжүүдтэй өрсөлдөхгүй байх, төрийн оролцоог бууруулах зэрэг суурь зарчмуудыг тусгасан нэгдсэн хууль одоогоор байхгүй байна.

Олон улсын туршлагаас харахад бизнес эрхлэх эрх чөлөөг хуульд тусгаж, төрийн оролцоог хязгаарлах нь бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчдын шийдвэр гаргалтад эерэг нөлөө үзүүлж, иргэд, олон нийт болон бизнес эрхлэгчдийн итгэлийг төрүүлж, төрийн бодлогын залгамж чанар, урьдчилан таамаглахуйц, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлдэг. Цаашлаад эдийн засаг, хөрөнгө оруулалтын өсөлтийг хангаж, тогтвортой байдлыг хадгалахад чухал нөлөөтэй гэж үзэж байна.

Манай улсын эдийн засгийн бүтэц, шилжилтийн үеийн эрх зүйн орчинтой тодорхой хэмжээгээр төстэй зарим орнуудад эдийн засаг, бизнесийн эрх чөлөөг хамгаалж, хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжих хүрээнд төрийн хэт оролцоо, хяналтыг бууруулж, баримт бичгийн шаардлагыг багасгаж, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр эрх зүйн шинэчлэл хэрэгжүүлсэн байна. Тухайлбал, Бүгд Найрамдах Казахстан Улс, Гүрж Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс, Бүгд Найрамдах Киргиз Улс болон Бүгд Найрамдах Эстони Улсын холбогдох эрх зүйн зохицуулалтыг сонгон судаллаа.

Бизнесийн эрх чөлөө нь бизнесийн үйл ажиллагааг хуульд хориглосноос бусад хэлбэрээр чөлөөтэй эрхлэх, гэрээ, хэлцэл байгуулах, өмч хөрөнгөө чөлөөтэй эзэмших, ашиглах, захиран зарцуулах, үр шимийг хүртэх, зах зээлд чөлөөтэй нэвтрэх, оролцохтой холбоотой эдийн засгийн эрх, баталгааг хамарсан суурь ойлголт юм.

Монгол Улсын Засгийн газрын тухай хууль болон Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасны дагуу Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсын хөгжлийн нэгдсэн бодлого, төр, хувийн хэвшлийн түншлэл, хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, хөрөнгө оруулагчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, эдийн засгийн болон хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох асуудал хамаардаг.

Иймд Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэн, хуулийн этгээдийн бизнесийн үйл ажиллагаа чөлөөтэй эрхлэх эрхийг баталгаажуулах, хувийн өмчийн халдашгүй байдлыг хангах, зах зээл дэх төрийн оролцоог бууруулах зэрэг Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогод туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 36.2 дахь хэсэгт заасан хууль санаачлах эрхийн хүрээ, хязгаарт үндэслэн

Бизнесийн эрх чөлөөний тухай анхдагч хуулийн төсөл, түүнийг дагаж Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон

холбогдох бусад хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн боловсруулна.

1.2.Практик шаардлага

Дэлхийн өв уламжлалын сангаас “Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс”-ийг эрх зүйт ёс, Засгийн газрын оролцоо, зохицуулалтын үр ашигтай байдал, нээлттэй зах зээлгэсэн нийт 4 бүлэг 12 шалгуур үзүүлэлтийг ашиглан тооцдог бөгөөд Монгол Улс 2025 онд нийт дүнгээрээ 184 улсаас 63.9 оноотойгоор 69 дүгээр байранд эрэмбэлэгдсэн байна.

Бүлэг	Шалгуур үзүүлэлт/дэд хүчин зүйлс	Оноо	Онооны ангилал	Байр
Эрх зүйт ёс	Өмчийн эрх	49.2	хаалттай	92/184
	Шүүхийн үр ашиг	54.9	хязгаарлагдмал	73/184
	Төрийн зарчимт байдал	35.8	хаалттай	114/184
Засгийн газрын оролцоо	Татварын ачаалал	83.7	чөлөөтэй	65/184
	Засгийн газрын зарлага	64.6	дунд	117/184
	Төсвийн сахилга бат	96.1	чөлөөтэй	33/184
Зохицуулалтын үр ашигтай байдал	Бизнесийн эрх чөлөө	68.4	дунд	76/184
	Хөдөлмөрлөх эрх чөлөө	68.2	дунд	17/184
	Мөнгөний эрх чөлөө	72.1	нээлттэй	116/184
Нээлттэй зах зээл	Худалдааны эрх чөлөө	74.4	нээлттэй	82/184
	Хөрөнгө оруулагчдад ээлтэй байдал	50.0	хязгаарлагдмал	114/184
	Санхүүгийн зах зээлийн нээлттэй байдал	50.0	хязгаарлагдмал	97/184

Шалгуур үзүүлэлтүүдийн оноогоор нийт 184 орноос “өмчийн эрх”-ийн үзүүлэлтээр 92-т эрэмбэлэгдэж “хаалттай”, “төрийн зарчимт байдал” үзүүлэлтээр 114-т эрэмбэлэгдэж “хаалттай”, “бизнесийн эрх чөлөө” үзүүлэлтээр 76-т эрэмбэлэгдэж “дунд”, “хөрөнгө оруулагчдад ээлтэй байдал” үзүүлэлтээр 114-т эрэмбэлэгдэж “хязгаарлагдмал” гэж үнэлэгдсэн байна. Үүнээс үзэхэд иргэдийн эд хөрөнгө өмчлөх, эзэмших эрх чөлөөг хангах, төрийн албаны авлигатай тэмцэх, бизнесийн үйл ажиллагаанд аливаа төрөөс тавьсан хязгаарлалтыг бууруулах, хөрөнгө оруулалтын эрсдэлийг багасгах шаардлагатай байгааг харуулж байна.

Энэ хүрээнд бизнес, хөрөнгө оруулалтын орчинтой холбоотой 7 чиглэлээр дүн шинжилгээ хийж, дараах хэрэгжүүлэх шаардлагатай цогц арга хэмжээг тодорхойлсон.

1.Бизнесийн үе шат бүрд үзүүлэх төрийн үйлчилгээ, тухайлбал хуулийн этгээд байгуулах, зөвшөөрөл олгох, төрөлжсөн бүртгэлд бүртгүүлэх болон бусад процессын шат дамжлага, үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлж хялбарчлах;

2.Зах зээлийн боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр зах зээл дэх төрийн оролцоог бууруулах;

3.Гадаад худалдааг хялбарчлах хүрээнд бүрдүүлэх баримт бичиг, зарцуулах хугацааг бууруулах;

4.Гадаадын хөрөнгө оруулагчдын эрх тэгш байдлыг хангах, хөрөнгө оруулалтын зохицуулалт, үр ашиг сул байдал, хүнд суртлыг бууруулах, хөрөнгө оруулалтын баталгааг хангах;

5.Маргаан шийдвэрлэлттэй холбоотой шүүхийн үйл ажиллагааны чанарыг сайжруулах, авлигын эрсдэлийг бүрдүүлж буй тогтолцооны гажуудлыг арилгах;

6.Төлбөрийн чадваргүй байдлыг шийдвэрлэх хугацааг багасгах;

7.Хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрийг хангах.

Монгол Улсын эдийн засагт 1994 оноос хойш уул уурхайн салбарын эзлэх хувь тэлж, уул уурхайн бус салбар, тэр дундаа хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувь агшжээ. Тухайлбал, уул уурхайн салбарын нийт ДНБ-д эзлэх жин өнгөрсөн 30 жилд 10 хувиас (1994) 26 хувь болж (2025) өссөн бол хөдөө аж ахуйн салбарын жин 27 хувиас 9 хувь, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын жин 17 хувиас 7 хувь болж тус тус буурсан байна.

Гадаад талаас сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнуудад бодлогын болон бүтцийн өөрчлөлтүүд явагдаж, худалдаа, хөрөнгө оруулалтын чиглэл өөрчлөгдөж байгаа энэ цаг үед дэлхийн улс төр, эдийн засгийн нөхцөл байдалд тодорхой бус байдал эрчимтэй нэмэгдэж байна. Худалдааны дайны цар хүрээ улам бүр тэлж болзошгүй байгаа нь дэлхийн эдийн засгийн идэвхжилийг хязгаарлах, инфляцыг өдөөх эрсдэлийг нэмэгдүүлсэн. Улмаар энэ нь манай улсын экспортын орлого буурах, инфляц өсөх, гадаад санхүүжилтийн өртөг, зардал нэмэгдэхэд шууд нөлөөлж болзошгүй байна. Иймд урт хугацаанд эдийн засгийг төрөлжүүлэх нь макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалахад чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Монгол Улсад 1990 оноос 2025 он хүртэл нийт 52.12 тэрбум ам.долларын гадаадын хөрөнгө оруулалт орж ирснээс 74 хувь нь уул уурхайн олборлолт, 10 хувь нь худалдаа, үйлчилгээний салбарт хийгдсэн бол бусад салбарууд нийлээд 16 хувийг эзэлж байгаа бөгөөд гадаадын хөрөнгө оруулалт төрөлжихгүй, зөвхөн нэг салбарт харьцангуй ихээр төвлөрч байна. Уул уурхайн олборлолт, бүтээн байгуулалттай холбоотойгоор сүүлийн 10 жилийн дунджаар гадаадын шууд хөрөнгө оруулалтын 50 хувийг “Оюутолгой” ХХК дангаар бүрдүүлж байгаа ба 2025 оны гадаадын шууд хөрөнгө оруулалтын 80 хувь нь уул уурхайн салбарт хамаарч байна.

Аж ахуйн нэгжийг гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын хэлбэрээр ялгаварласан, үйл ажиллагаа явуулахыг хориглосон, хязгаарласан зохицуулалт

болон төрийн үйлчилгээ үзүүлэхэд тавигдах шаардлага, хүсэлтээ шийдвэрлүүлэх хугацаа, төлбөр хураамжийг ялгамжтай тогтоосноос шалтгаалан гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд хараат болон охин компани, компанийн нэгдлийг байгуулж байгаа нь гадаадын шууд хөрөнгө оруулалтын бодит үр өгөөжийг тодорхойлох, хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогыг тодорхойлоход хүндрэл үүсгэсээр байна.

Мөн Монгол Улсад хөрөнгө оруулалт хийж, үйл ажиллагаа явуулах боломжийг хязгаарлаж, хориглосон, эсхүл гадаадын иргэн, хуулийн этгээдэд нэмэлт шаардлага тавьсан хуулиуд байх бөгөөд эдгээрээс зүй ёсны буюу байх ёстой шаардлагыг тогтоосон хуулиудаас гадна гадаадын иргэн, хуулийн этгээдийг Монгол Улсад аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, хөрөнгө оруулах боломжийг хязгаарласан, хориглолт тогтоосон, ач холбогдолгүй нэмэлт шаардлагыг бий болгосон хэд хэдэн хууль хүчин төгөлдөр үйлчилж байна.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд дотоод, гадаадын хөрөнгө оруулагчид, бизнес эрхлэгчдийн өмчлөх эрхийг хамгаалах, бизнесийн үйл ажиллагаагаа чөлөөтэй, саадгүй явуулах боломжийг бүрдүүлсэн эрх зүйн орчныг цогц байдлаар шинэчлэх, тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдуулан бизнес эрхлэгчдийн эрхийг бодитой, үр дүнтэй хамгаалах, хөрөнгө оруулагч болон төр хоорондын ашиг сонирхлыг харилцан тэнцвэртэйгээр хамгаалан зохицуулах нь чухал байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд шинээр хөрөнгө оруулалт татахаас гадна, нэгэнт хөрөнгө оруулсан хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, үүссэн асуудлыг хуулийн дагуу шуурхай шийдвэрлэх, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх нь чухал ач холбогдолтой. Олон улсад гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгалын 50 орчим хувийг дахин хөрөнгө оруулалтын орлого бүрдүүлдэг байна.

Монгол Улсын хувьд зарим төрийн болон нутгийн байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд, албан тушаалтнуудын хариуцлагагүй үйлдэл, эс үйлдлээс үүдэн Засгийн газар олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг, амлалтаа биелүүлэхгүй байх, гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг алдах, цаашлаад манай улсын хөгжлийн зорилтод чухал хувь нэмрээ оруулдаг гадаад түнш орнуудтай харилцах харилцаанд ноцтой үр дагавар учруулах болзошгүй тохиолдлууд гарах эрсдэлийг бий болгож байна.

Одоогийн Хөрөнгө оруулалтын тухай хуульд хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр дэмжлэг, үйлчилгээ үзүүлэхээр орон тооны бус зөвлөлтэй байхаар тусгасан боловч гомдлын төрөл, гомдлыг шийдвэрлэх процесс тодорхойгүй байснаар хөрөнгө оруулагчийн гомдлыг шийдвэрлэхэд хүндрэлтэй байдаг.

Түүнчлэн Улсын Их Хурлаас 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр Зөвшөөрлийн тухай хуулийг баталж, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан 1000 гаруй төрлийн тусгай зөвшөөрлийн тоог 14 чиглэлийн салбарт 251 “тусгай зөвшөөрөл”, 130 “энгийн зөвшөөрөл”, нийт 381 төрлийн зөвшөөрөл болгон бууруулж хуульчилсан. Зөвшөөрлийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд нийт 16 зөвшөөрлөөр буюу боловсролын салбарт 4, байгаль орчны салбарт 3, банк, санхүүгийн салбарт 2, хүнс, хөдөө аж

ахуйн салбарт 2, батлан хамгаалах салбарт 2, хууль зүйн салбарт 1, аймаг, нийслэлийн засаг даргаас олгох 2 зөвшөөрөл тус тус нэмэгдсэн байна.

Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайланд дурдсанаар Зөвшөөрлийн тухай хуулиар салбар бүрийн зөвшөөрөл олголтын процессыг нарийвчлан зохицуулах боломжгүй бөгөөд салбарын хуулиар энэ төрлийн харилцааг хуульчилж өгөөгүйтэй холбоотойгоор салбар бүр захиргааны хэм хэмжээний акт батлан зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг зохицуулж байгаа нь тус хуулийн 1.5 дугаар зүйлийн 17 дахь хэсэгт заасан “Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно” гэж заасантай зөрчил үүсгэж байна.

Хууль тогтоомжид зөвшөөрөл гэж нэрлэгдээгүй боловч бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд шаарддаг, төрийн байгууллагаас олгодог баримт бичгүүдийг Төрийн хэмнэлт, бүтээмжийн зөвлөлөөс судалж үзэхэд Монгол Улсын хуулиудад бүртгэл 264, дүгнэлт 232, гэрчилгээ 132, магадлан итгэмжлэл 30, сертификат 9 байна гэсэн үр дүн гарч, зөвшөөрөл олгох процесстой адилхан процессыг бүрдүүлж байгаа нь Зөвшөөрлийн тухай хуульд заасан “Хүн, хуулийн этгээд хуулиар хориглосон, эсхүл энэ хуулийн 8.1, 8.2 дугаар зүйлд заасан тусгай болон энгийн зөвшөөрөлтэйгөөр эрхлэхээс бусад төрлийн үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн чөлөөтэй эрхэлж болно” гэж заасантай зөрчил үүсгэж байна.

Дээр дурдсан нөхцөл шалтгаануудыг харгалзан бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчдад ээлтэй байдал, зохицуулалтын үр ашигтай байдлыг сайжруулах, эрх ашиг сонирхлыг нь хамгаалах, хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэх, хувийн хэвшлийн үйл ажиллагаанд төрийн оролцоог бууруулах, зөвшөөрлийн процессыг цахимжуулж, хялбаршуулах, бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх зорилгоор Бизнесийн эрх чөлөөний тухай анхдагч хуулийн төсөл, түүнийг дагаж Хөрөнгө оруулалтын тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль болон бусад холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна.

Хоёр.Хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ:

Энэ хуулиар Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан иргэн, хуулийн этгээдийн бизнесийн үйл ажиллагаа эрхлэх эрх, бизнесийн орчин дахь төрийн оролцооны хязгаарыг тогтоох, шударга өрсөлдөөнийг дэмжихтэй холбогдсон харилцааг зохицуулж, уг зорилтыг хэрэгжүүлэхтэй холбоотой зарчмуудыг хуулийн төслийн Нэгдүгээр бүлэгт тусгана.

Түүнчлэн хуулиар хориглосноос бусад тохиолдолд төрөөс бизнесийн эрх чөлөөг хязгаарласан, хориглосон хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт батлан гаргах, үндэслэлгүйгээр бизнес эрхлэгчийн нэр хүндэд халдсан мэдээлэл гаргах, түгээх, бизнес эрхлэгчийг нийгмийн хариуцлагын үйл ажиллагаанд албадан оролцуулах, төрөөс бизнесийн үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөх, оролцох, үндэслэлгүй хяналт, шалгалт хийх, өмч хөрөнгийг нь хууль бусаар хураан авах, дайчлах, хуульд заагаагүй төрийн хяналт, шалгалт хэрэгжүүлэх захиргааны шийдвэр гаргаж, дүрэм, журам батлах, зэрэг төрийн бодлого, үйл ажиллагаанд хориглох зүйлсийг тусгана.

Мөн хуулийн төслийн Хоёрдугаар бүлэгт хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагын талаар тусгана.

Гурав.Хууль батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал:

Энэ хуулийн төсөл батлагдсанаар дараах эдийн засаг, нийгэм, хууль зүйн эерэг үр дагаврыг бий болгоно:

1/Иргэн, хуулийн этгээдийн бизнесийн үйл ажиллагаа дахь төрийн оролцоог бууруулах, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, өрсөлдөөнт, чөлөөт зах зээлийн эдийн засгийг бүрдүүлж, бизнес эрхлэгчдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах суурь зарчмыг бий болгоно;

2/Иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд төрөөс оролцох буюу тэдгээрийг дур зоргоороо шийдвэр гаргах боломжийг хязгаарлана;

3/Уул уурхайн салбараас хэт хамааралтай, гадаад зах зээлийн савлагаанд мэдрэмтгий эдийн засагтай Монгол Улсын хувьд тогтвортой, өрсөлдөх чадвартай, ил тод эдийн засгийн тогтолцоонд шилжиж, зах зээлд суурилсан урт хугацааны өсөлтийг дэмжих, хөрөнгө оруулалтын орчин, итгэлцлийг нэмэгдүүлнэ;

4/Зах зээлийн өрсөлдөөн, хувийн хэвшлийн санаачилгыг дэмжиж, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ;

5/Бизнес эрхлэхэд таатай орчныг бүрдүүлж, авлига, хүнд суртал, албан тушаалтны үйл ажиллагаанаас хамааралтай байдлыг багасгана;

6/Хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдэж, гадаадын шууд хөрөнгө оруулалт татах, дахин хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх, хөрөнгө оруулагчийн хууль ёсны баталгааг хангах, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах нөхцөлийг бүрдүүлнэ;

7/Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, зөвшөөрлийн процессыг хялбаршуулж, цаг хугацаа, зардлыг хэмнэж, төрийн үйлчилгээг түргэн, шуурхай хүргэнэ.

Бизнесийн эрх чөлөөний тухай хууль, түүнийг дагаж Хөрөнгө оруулалтын тухай, Зөвшөөрлийн тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар улсын төсөвт ачаалал үүсгэхгүй болно.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал:

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд нийцүүлэн боловсруулах бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Авто замын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Авто тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ажиллах

хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Арбитрын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Боловсролын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын хэвлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Генетик нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Геодези, зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэрийн тэжээвэр амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэрээт харуул хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Дипломат албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зар сурталчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зээлийн мэдээллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мал, амьтны тэжээлийн нэмэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Малын генетик нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Оюуны өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тамхины хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Таримал ургамлын үр, сортын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тэсэрч дэлбэрэх бодис,

тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Усан замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгалийн ургамлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хог хаягдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хот, суурин ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөө, аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хувийн хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хувиргасан амьд организмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шилэн дансны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүх шинжилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсруулна.

--oOo--